

Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 24/6 тоот тогтоолын хавсралт 3

ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ  
ЗӨВЛӨЛ

ДАРХАН-УУЛ АЙМАГ

## ДАРХАН НЭХИЙ ХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

**Зорилго:** ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.

1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна.
2. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.
  - 2.1. Компанийн тогтвортой өсөлтийг хангах, дунд болон урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход бусад оролцогч талууд (компанийн ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч, компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэн)-ын хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх шаардлагад нийцэж ажиллах
  - 2.2. Компанийн хөгжлийн стратегийг хариуцдаг чиглүүлэгч бүтцийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.
3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.
  - 3.1. Оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо үүсгэхийн тулд олон улсын сайн туршлагауудыг нэвтрүүлэн тэдэнд хамаарах санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.
4. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.
5. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.